



2010 оны 6-р сар

Шинэ Мэдэц

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН СЭТГҮҮЛ

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА - ТАНЫ ТӨЛӨӨ



Энэ дугаарт:

- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр “Хөдөлбөл хөлс” хөтөлбөрийн хүрээнд 20 мянга гаруй малчдад дэмжлэг үзүүлээ
- Зудын олон талын сөрөг үр дагавар айл өрх, хүүхдийн амьдралд хүндээр тусч байна
- Зуданд нэрвэгдсэн эмэгтэйчүүд, хүүхдүүдэд урт хугацааны тусламж үзүүлэх нь
- ДЭМБ-ын Монгол Улстай Хамтран Ажиллах Стратеги 2010 - 2015
- Нийслэлийн гэр хорооллын оршин суугчид амьдрах орчин нөхцлөө сайжруулах үйлсэд хошуучлан оролцож байна
- НҮБ-ын ХХААБ-ын Гамшгийн аюулаас хамгаалах ба сэргээн босго тусламжийг зохицуулах нэгж (ERCU)
- Хүүхдийн хөдөлмөрийг устгах нь үндэсний зорилт юм

© НҮБ-ын Мэдээллийн алба
И-мэйл: registry.mn@undp.org
Утас: 976-11-327585
Факс: 976-11-326221

Вэб хуудас: <http://www.un-mongolia.mn>
Зургийг: НҮБ-ын зургийн архив

ӨМНӨХ ҮГ

Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын мэдээллийн сэтгүүлийн энэ удаагийн дугаарт 2009-2010 онд тохиолдсон зудын хүндрэлтэй холбоотой асуудал, тухайлбал тулгамдсан саад бэрхшээл, авч хэрэгжүүлсэн болон одоо үргэлжилж буй арга хэмжээ, цаашид ийм нөхцөлд бэлэн байдлыг хангахын тулд засгийн газрын болон бусад байгууллага, түншүүдийн хамтаар бид бүгдийн хамтаар анхаарах шаардлагатай тодорхой туршлага, сургамжийн талаар голчлон толилуулж байна.

Энэхүү асуудалд олон улсын түвшинд анхаарлыг хандуулахад улс орон даяар мал сүргийн тоо толгой их хэмжээгээр хорогдож, малаа алдсан хүмүүсийн амьдралд энэ хохирол хэрхэн хүндрэлтэй тусаж байгаа талаар тодорхой мэдээллийг хүргэх, олон жилийн турш яригдаж байгаа ч ахиц дэвшил, өөрчлөлт багатай байгаа бэлчээрийн менежмент, малын чанарыг сайжруулах талаарх асуудлаас гадна хүмүүнлэгийн тусламжийг яаралтай үзүүлэх тулгамдсан арга хэмжээг шийдвэрлэх нь чухал байв. Зудын хор уршиг, сөрөг нөлөө олон янзын хэлбэрээр илэрч байгаа ч зудад нэрвэгдсэн аймгуудад хүүхдийн эндэгдэл эрс нэмэгдсэн нь хамгийн ноцтой хохирол билээ.

Хэдийгээр урин цаг ирсэн ч зудын уршиг арилаагүй ч, үр дагавар нь ард иргэдийн хувьд үргэлжилсээр, НҮБ болон бусад хамтын түншүүд хүмүүнлэгийн тусламжийг үзүүлсээр байна. Ялангуяа дотоодын шилжин суурьшилтын асуудалд анхаарал хяналт тавих, дахин хүндрэл бэрхшээлтэй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх, хор хохирлыг бууруулах талаар тодорхой алхмуудыг авч байна.

Хөдөө орон нутгийн ард иргэдэд нэн шаардлагатай тусламжийг цаг тухайд нь хүргэх, нийгмийн сэтгэл зүйн хувьд дэмжлэг үзүүлэх, малчдад малын тэжээл, мал эмнэлгийн шаардлагатай эм тариа, бэлдмэлээр хангах, малын сэг зэмийг устгах ажилд дэмжлэг үзүүлэх хөрөнгө мөнгийг шийдвэрлэх зэрэгт тодорхой үр дүнд хүрсэн. Гэвч хүндрэл бэрхшээл олон сарын турш үргэлжлэх нь тодорхой байна. Хандивлагч, доноруудад хандан гаргасан Нэгдсэн уриалгын үр дүн эхэн үедээ удаашрилтай байгаа боловч гамшгийн эсрэг бэлтгэлтэй байдал, авах хариу арга хэмжээний нэгдсэн зохицуулалтыг олон улс орон ойлгон дэмжиж, тусламж үзүүлнэ гэдэгт бид бүрэн итгэлтэй байна.

2010 оны эхний сарууд НҮБ-ын хувьд бусад олон асуудлаар тун завгүй байлаа. Тухайлбал, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд Монгол Улсын засгийн газрын илтгэл танилцуулгыг бэлтгэж боловсруулах, Монгол

Улсын хүний эрхийн асуудлаар Хүний Эрхийн Зөвлөлд хоёр тайлан бэлтгэх, Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийн байдлыг дэмжин сурталчлах зэрэг хийгдсэн ажлыг дурдаж болох юм.

Монгол Улс олон улсын тавцанд хүний эрхийн асуудлаар дорвитой алхмуудыг авч хэрэгжүүлж байгаа нь олон улсын зүгээс сайшаал дэмжлэг авч байгаа бөгөөд ялангуяа цаазаар авах ялыг цуцлах талаар шийдвэр гаргасан нь ялангуяа Европ болон Азийн бүсийн олон орны зүгээс сайшаал дэмжлэг авсан.

Өнөөдөр Монгол орны хувьд шийдвэрлэх чухал бөгөөд сонирхолтой цаг үе ирээд байна. Байгалийн баялагийн олборлолт, ашиглалттай холбоотойгоор Дотоодын нийт бүтээгдэхүүний /ДНБ/ хэмжээ нэмэгдэж, Монгол орны ирээдүйн дүр зураг эрч хүчээр дүүрэн харагдаж байна. Бидний нийтлэг зорилго бол эдийн засгийн өсөлттэй хамт хүний хөгжлийг эн зэрэгцээ дэмжин тэтгэх явдал юм. Хэзээ хэзээнээс илүү энэ цаг үед ядуурал, тэгш бүт байдлыг арилгах, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, сайн засаглалыг хэрэгжүүлэх, нийгмийн хамгаалал, даатгалын тогтолцоог бэхжүүлэх, чухал салбарууд дахь хүйсийн тэгш байдлыг хангах, ирээдүйн ажиллах хүчийг бэлдэх, улс орон даяар ус хангамж, эрүүл ахуйн системийг бий болгох, дэд бүтцийг хөгжүүлэх болон байгаль орчныг хамгаалах зэрэг асуудлаар дорвитой бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд тохиромжтой цаг үе ирээд байна.

Энэ бүхнийг НҮБ-ын зүгээс дэмжин туслахад хэзээд бэлэн байдаг. Ирэх таван жилийн улс орныг дэмжих хөтөлбөр төлөвлөлт, боловсруулалт эхэлсэн бөгөөд 2015 он хүртэл Мянганы Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилтийг хангах асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Энэ оны долдугаар сард Монгол Улс дахь НҮБ-ын шинэ Суурин зохицуулагч хатагтай Сезин Синаноглу ажилдаа орж, дээрх үйл явцыг удирдах, шаардлагатай зохицуулалт, уялдаа холбоог хангах ажлыг үргэлжлүүлэх болно.

Эцэст нь хамтран ажилладаг бүх түншдээ хувийнхаа зүгээс болон хамт олны зүгээс биднийг урамшуулан зоригжуулж, илэндалангүй, шударга, нээлттэй харилцах боломжийг олгодогт, Монгол оронд хүний эрхийг улам дээдлэн хүндэтгэж, монголчуудын амьдралд бодитой өөрчлөлт гаргах үйлсэд хамтын хувь нэмэр оруулж байгаад чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна.

Рана Флауэрс
НҮБ-ын Суурин зохицуулагчийн үүрэг гүйцэтгэгч



НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Mongolia

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР “ХӨДӨЛБӨЛ ХӨЛС” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 20 МЯНГА ГАРУЙ МАЛЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ

Хахир өвөл шувтарсан ч хаврын хавсарга залгаж хүн мал ялгаагүй туйлджээ. Өнгөрсөн өвлийн зуд турханд хорогдсон сая сая малын сэг зэм ил задгай орхигдсон хүндхэн нөхцөл байдалтай байна. /2009-2010 онд 8,5 сая гаруй мал хорогдсон байна. Эх сурвалж: Хүнс Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам /

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын малчин Буянбатынх өөр бусад малчин өрхийн адил хүнд бэрх байдалд оржээ. Буянбат соргог бэлчээр бараадаж малаа тусаар Уянга сумаас ирсэн аж. Түүний эхнэр нь хөл хүндтэй, дөрвөн хүүхэд нь аймгийн төвд сургуульд сурч дотуур байранд суудаг. Өнгөрсөн оны намар гэхэд тэднийх 1000 гаруй бог, 300 бод малтай байжээ. Гэвч энэ өвлийн зуднаар хамаг малаа алдаж, ердөө зуу хүрэхгүй бог малтай үлдсэн байна. Буянбатынх бүр 9-р сараас л зэргэлдээ Хужирт, Зүүнбаян-Улаан сумаар дамжин нүүж, өвс устай бэлчээр хайсан аж. Дараахан нь зуд нүүрлэж, долоон сарын турш хүйтний эрч сулрахгүй үргэлжлэв. Энэ жилийн өвөл хүйтэн хахир ч гэж тоймгүй байлаа. “Хэзээ ч энэ жилийнх шиг ийм хүйтэн өвөл ойрын жилүүдэд болж байгаагүй. Манайх 15 жил хөдөлмөрлөж байж өсгөсөн малаа нэг л өвөл алдчихлаа шүү дээ” гэж Буянбат хоолой зангируулан ярьж байна. Гэвч тэрээр тэсвэр заан байж “За яах вэ, нас залуу байна, мал сүргээ дахиад л өсгөнө дөө” гэж хэлсэн юм.

Энэ өвөл хамрах хүрээний хувьд 1987 оны зуднаас ч илүү хахир зуд болж, 8,5 сая толгой мал (нийт малын бараг 20 хувь) хорогдож малчдад маш хүнд цохилт боллоо. Зудын уршгаар Буянбатынх адил малчин гэр бүл нэгэн зэрэг хоёр бэрхшээлтэй тулгарсан. Тэд энэ гамшгийн улмаас амьжиргаа орлогын үндсэн эх үүсвэрээ алдлаа. Хөдөө

нутгийн олон монгол хүмүүсийн хувьд мал ахуй бол гол амьжиргаа байдаг бөгөөд олон өрх орлогын болон хүнс тэжээлийн эх үүсвэргүй боллоо. Мөн дээрээс нь нэрмээс болж бэлчээрт ил задгай орхигдсон сэг зэм малчдын эрүүл мэнд, байгал орчинд ихээхэн эрсдэл учруулж байна. Ялангуяа суурин газар болон ундны усны эх үүсвэрт ойр байгаа нь халдварт өвчин тарах эрсдэл үүсгээд байна. Хавар болж цас хайлж эхэлмэгц үхсэн малын сэг зэм хөрс, ус бохирдуулах, халдварт өвчин гарах, тархах аюулд хүргэж болзошгүй. Тиймээс малчдад малын сэг зэмийг булж устгах нөр их ажил тулгарч байна.

Үүссэн нөхцөл байдалд Монгол Улсын Онцгой Байдлын Ерөнхий Газар улс орон даяар малын сэг зэмийг булж устгах хөтөлбөр боловсруулж ажилласан юм. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр энэхүү санаачилгыг дэмжиж малчдыг дэмжих “Хөдөлбөл хөлс” хөтөлбөр хэрэгжүүлэн аймаг, орон нутагт туслахаар болсон. Энэ хөтөлбөрт хамрагдсан малчид иргэд нь малын сэг зэмийг устгах ажилд оролцсоноор ажлын хөлс авах юм. Ингэснээр малчид богино хугацаанд бага ч гэсэн орлого олж, гэр бүлдээ дэм болж, хүнсний өдөр тутмын хэрэгцээг хангах боломжтой болохын зэрэгцээ амьдрах орчин, усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалан, хүмүүсийн эрүүл мэндэд учрах эрсдлийг бууруулахад хувь нэмэр оруулах болно.

“Манайх зуун малтай байсан. Ихэнхийг өнгөрсөн зуднаар алдаад ердөө 20 богтой л удлээ. Би гэр бүл, хоёр хүүхдээ тэжээх хэрэгтэй байна. Амьжиргаагаа юугаар залгуулахаа мэдэхгүй арга барагдаж байна. Одоохондоо малын сэг зэм булж бэлэн мөнгө авах ажилд л оролцож явна даа” – гэж Өвөрхангай аймгийн Уянга сумын малчин, 31 настай А хэллээ.

“Хөдөлбөл хөлс” хөтөлбөр эхэллээ

“Сумын төвөөс ах дүү нарын явуулсан гурил одоо бараг дуусаж байна. Зам цасанд боогдсон болохоор сум орж хүнсээ базааж чадахгүй л байна” – гэж Ховд аймгийн Үенч сумын өндөр настай малчин эмэгтэй ярилаа.

“Хөдөлбөл хөлс” хөтөлбөр зуданд хамгийн ихээр нэрвэгдсэн Өвөрхангай, Дундговь, Ховд аймагт явагдаж байна. Онцгой Байдлын Ерөнхий Газар НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр болон орон нутгийн засаг захиргаатай хамтран 20,000 малчинд хүрч ажиллаж байгаа нь дээрх гурван аймгийн нийт малчин өрхийн 60 гаруй хувьд хүрэх юм. Хөтөлбөрт 200-аас доош тооны малтай айл өрхүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, бусад эмзэг бүлгийн малчдыг нэн түрүүнд сонгон оролцуулж байна.

“НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр байгалийн гамшгийн үед бэрхшээлийг даван туулахад дахин тэргүүлэх үүрэг гүйцэтгэн дэмжлээ” хэмээн ОБЕГ-ын орлогч дарга Д. Намсрай хэлсэн. Аймгийн Онцгой байдлын хэлтсийн

удирдлага дор малчид нийт 2 сая малын сэг зэмийг булж устгах ажил хийсэн нь 5-р сарын байдлаар малын нийт хорогдлын 25 хувь болж байна. Энэхүү санаачлагат ажилд оролцсон малчин бүр хөдөлмөрийн хөлсөнд 70 ам. доллар авах ба энэ нь дундаж өрхийн гурван сарын хэрэглээний гурил, будаа нөөцлөхөд хүрэлцээтэй хэмжээний мөнгө юм.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр “Хөдөлбөл хөлс” хөтөлбөрт 1,8 сая ам. доллар зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд цаашид малчдад урт хугацаанд дэмжлэг үзүүлэх, Монгол Улсад зудын уршгийг арилгах эрт үеийн сэргээн босголтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт хөрөнгийн үүсвэр олохоор үргэлжлүүлэн ажиллаж байна.

“Зуднаар хамгийн их хохирол хүлээсэн цөөн малтай малчид, эмэгтэйчүүдэд нэн даруй хөдөлмөр эрхлэх боломж олгож тусалж байна. Цаашид урт хугацаанд тэдгээр малчдыг амьжиргааны шинэ үүсвэртэй болгох чиглэлд үргэлжлүүлэн ажиллах бодолтой байгаа” гэж НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн суурин төлөөлөгч Акбар Усмани ярьж байна.

“Ийм төсөл хэрэгжиж байгаад бид нар их баярлаж байгаа, хөлсөө аваад хүүхдүүддээ л зориулна даа” – Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын малчин эмэгтэй.


“Манайх ихэнх малаа зуданд алдчихсан. Одоо амьдрал их хэцүү байна. Гэхдээ нутгийн ах дүүс, төр засгийн дэмээр тэсээд гарах л байх, хойшдын амьдралдаа итгэсээр л байгаа шүү” – Өвөрхангай аймгийн малчин, 38 настай А.

Хөтөлбөр иргэдийн оролцоонд тулгуурлана

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр “Хөдөлбөл хөлс” хөтөлбөрийг ил тод, тэгш оролцоотой хэрэгжүүлэхэд онцгой анхаарч байгаа юм. Сумын засаг дарга нар хөтөлбөрийн эхэн үед хөтөлбөрт оролцох иргэдийн нэрсийг зарлаж байгаа бөгөөд хөтөлбөрийн ажил дууссаны дараа хөлс авах иргэдийн нэрсийг суманд хамгийн их хүн орж гардаг Засаг

даргын тамгын газар болон ХААН Банкны мэдээллийн самбарт гаргах юм. Алслагдмал нутгийн малчид Үндэсний Радиогийн тогтмол нэвтрүүлгээр хэрэгтэй зарлал, мэдээллээ хүлээн авах боломжтой. Одоогийн байдлаар нийт ажлын 80 орчим хувийг гүйцэтгээд байна.

ЗУДЫН УРШГИЙГ АРИЛГАСНЫ ДАРАА ЯАХ ВЭ? “МАЛЧИД ИРЭЭДҮЙГЭЭ ӨӨДРӨГӨӨР ХАРЖ БАЙНА”



Хөхөө өвөл хойно хоцорсон ч зудын хохирлын гол уршиг хавар цагт л мэдэгддэг. Нийт нутгаар мөд дулаарах янзгүй, зузаан цас дарж, хүн мал зутарсаар л байна.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр малчдад богино хугацааны дэмжлэг үзүүлээд зогсохгүй урт хугацааны хэрэгцээг нь шийдэхэд ч бас туслахыг зорьж байна. Өмнөх туршлагаас үзэхэд зудаас сэргэлийлэхэд бэлтгэлийг сайтар базаах нь сайн үр дүнд хүрсэн байна. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент” төсөлд хамрагдсан орон нутагт саяхны хийгдсэн үнэлгээгээр бусад нутгийг бодвол хавьгүй цөөн мал хорогдсон үр дүнтэй гарсан. Энэ нь сүүлийн жилүүдэд хийсэн шинэлэг ажил, жишээлбэл хадлангийн талбайг хадлан авахаас гадна өвөл, хавартаа төл мал, ядарсан малаа оруулах зорилгоор хашсаны үр дүн юм. Тиймээс энэ төсөлд илүү олон малчдыг хамруулахаар шийдээд байгаа юм.

Тухайлбал Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын малчин Чулуунбаатарын Шижирбаатар энэ төсөлд хамрагдсаны ачаар зудын гамшгийг амжилттай давжээ. Шижирбаатар 2009 онд байгуулагдсан малчдын “Бүрд” бүлгийн ахлагч. Түүний удирдсан бүлэгт 19 эрэгтэй, 19 эмэгтэй, нийт 38 малчны есөн өрх багтдаг. Бүлэг нийт 2692 малтай. “Бүрд” бүлэг Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент төсөлд хамрагдаж хашаа татах төмөр утас авсан. Бүлгийн гишүүд эрсдлийн менежментийн хүрээнд хадлангийн

талбайгаа мал орохоос хамгаалан хашиж, намар нь 60 тонн хадлан бэлтгэжээ. Тэд бэлдсэн өвснийхөө талыг малдаа өгч, талыг нь хөрш саахалтын малчдад хөнгөлөлттэй үнээр худалдсан байна. Өвс борлуулсан орлогоороо бүлгийнхээ эргэлтийн санг бүрдүүлж, гишүүддээ бага хүүтэй зээл олгосон байна.

“Энэ жил бид өвс бэлдсэний ачаар малын хорогдол багатай онд орлоо. Хадлан л аминд орлоо доо. Манай малын хорогдол сумын бусад малчдынхаас 50-60 хувиар бага байсан шүү” гэж Шижирбаатар ярив.

Цаашид Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр сонгогдсон гурван аймагт малчдад орлогын шинэ эх үүсвэр бий болгох боломж бүрдүүлэх талаар дэмжин ажиллана. Үүний тулд эхлээд Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран орон нутагт үнэлгээ хийж, жижиг бизнес эрхлэх малчдад дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлжээ. Чухам энд л НҮБ болон олон улсын байгууллагууд хамтарч малчдын амьжиргааг дэмжих шинэ арга зам, орлогын шинэ үүсвэрийн боломжийг эрж хайх хэрэгтэй юм. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр мөн бэлчээрийн менежментийн үндэсний бодлогыг хянан үзэж, улс орон даяараа зудын эрсдлээс сэргийлэх, бэлэн байдлыг хангах тогтолцоо бий болгох чиглэлээр Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамтай хамтран ажиллаж байна.

“Би шантрахгүйг хичээнэ ээ. Аль болох өөдрөг байж, хамаатан садантайгаа нийлээд амьдралын шинэ арга зам олж, гэр бүлээ аваад явж чадна.”

- Дундговь аймгийн малчин
2010 оны 05 сар

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр бол эерэг өөрчлөлтийн төлөө тэмцэж, улс орнуудад мэдлэг, туршлага, нөөц бололцоог түгээн дэлгэрүүлж, дэлхийн улс түмнүүдэд амьдралаа сайжруулах чадавхи бий болгохоор ажилладаг байгууллага, НҮБ-ын дэлхий дахины хөгжлийн сүлжээ юм.

Хүн бүрийн сайн сайхан амьдралын төлөө.

www.undp.mn

ЗУДЫН ОЛОН ТАЛЫН СӨРӨГ ҮР ДАГАВАР АЙЛ ӨРХ, ХҮҮХДИЙН АМЬДРАЛД ХҮНДЭЭР ТУСЧ БАЙНА

Өнгөрөгч өвлийн зуданд мал сүрэг их хэмжээгээр хорогдоод зогсоогүй, айл өрхүүд бэлэн мөнгө, хоол хүнс, түлээ түлш зэрэг амьжиргааны наад захын хэрэгцээгээ ч хангах боломжгүй нөхцөлд орж, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдал, боловсролын үйлчилгээнд сөрөг үр дагавар хүндээр туссан юм.

Урьдчилан сэргийлэх боломжтой шалтгааны улмаас гарч буй хүүхэд эмэгтэйчүүдийн эндэгдэл, хоол тэжээлийн хурц (хоол хүнсгүй болсноос үүдэлтэй) ба архаг (хэрэглэж буй хоол тэжээлийн чанар, нэр төрөл хангалтгүйгээс үүдэлтэй) хэлбэрийн хомсдол, түлээ түлшгүй болох зэрэг ноцтой үр дагаврууд зудын улмаас гарч байна. Зудтай байсан хугацааны сүүлийн үе шатуудад ч айл өрхүүд амьжиргаагаа залгуулан, хоол хүнстэй залгаж, ахуй амьдралаа сэргээн босгоход асар их бэрхшээлтэй тулгарч байв.

Хүүхдэд тулгарч буй эрсдлийг бууруулахад Эрүүл Мэндийн Яаманд дэмжлэг үзүүлэх зорилгоор зудад нэрвэгдсэн 12 аймгийн 133 сумдад НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрүүл мэнд, хоол тэжээлийн эн тэргүүний шаардлагатай материалын тусламж үзүүллээ. Үүнд амьсгалын замын өвчнийг эрт эмчлэх, суулгалт, төрөхийн болон нярайн асаргаа сувилгаанд шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэл багтсан байна.

Мөн НҮБ-ын Хүүхдийн Сангаас 6-24 сартай хүүхдүүд, эхчүүдэд зориулан олон найрлагат бичил тэжээлийн бодис, төмрийн бэлдмэл, сумдын эмнэлгүүдэд зориулан хүүхдийн өсөлтийг хэмжих хэрэгсэл, хурц хэлбэрийн хоол тэжээлийн дутагдалд орсон хүүхдүүдэд зориулан эмчилгээний хоол тэжээл, зудад нэрвэгдсэн хүн амд зориулан баяжуулсан гурил зэргийн тусламж үзүүлээд байна.

Урт өвлийг хомс өвс тэжээлээр арайхийн давсан мал сүрэг туйлдаад зогсохгүй, айл өрхийн өдөр тутмын хоол хүнс ч улам бүр хомс болдгоос шалтгаалан хүүхэд эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдал ч хүндэрдэг. Энэ нь дархлааг

сулруулж, урьдчилан сэргийлж болохуйц өвчлөлд өртөх эрсдлийг нь нэмэгдүүлдэгийн зэрэгцээ хүүхдүүдийн сурах чадварт нөлөөлж ирээдүйд эрүүл мэндийн ноцтой сөрөг үр дагавар бий болгох эрсдэлтэй. Мөн хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлууд ч бий болж байна – хүүхдүүд сургууль завсардаж, гэр бүлийнхээ амьжиргаанд нэмэр болохын тулд хөдөлмөр эрхлэхээс аргагүй байдалд хүрч байна. Олон сая малын сэг зэм нэмэгдэхийн хэрээр малчдын сэтгэлийн дарамт ч тэр хэмжээгээр нэмэгдэж, сэтгэл гутрал зэрэг нийгэм сэтгэл зүйн хүндрэл бэрхшээлүүд нэмэгдсээр байна.

“Зуны урин цаг ирж байгаа ч ядуу хүн амд учирсан хохирол улам нэмэгдсээр байна” хэмээн НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч Рана Флауэрс тэмдэглэв. “Хүмүүсийн амь нас эрсдэж байгаа тэвчишгүй гарз хохирол ч гарч байна. Нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжтэй холбоотой хот хөдөө дэх тэгш бус байдлыг зуд улам гүнзгийрүүллээ. Жил бүр өвөлжилтөд бэлдэхдээ өмнөх туршлага сургамжаасаа суралцаж, өвлийн бэлтгэлийг сайтар базааж, түлээ түлш, эм тариа, хоол хүнс зэрэг чухал шаардлагатай зүйлсээ нөөцлөх шаардлагатай байна.” хэмээн хатагтай Флауэрс тэмдэглэв.



© UNICEF Mongolia/2010/Andrew Cullen

Зудын эхэн үеэс НҮБ-ын Хүүхдийн Сан орлогынхоо эх үүсвэрийг алдсан, хоол хүнс, түлээ түлшгүй болж, хүүхдийн эрүүл мэнд, боловсролын байдал хүндэрсэн газруудын айл өрх, хүүхдүүдэд тусламж үзүүлэх талаар

Засгийн Газар, үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. НҮБ-ын Хүүхдийн Сан нь Хүмүүнлэгийн Тусламжийг Зохицуулах Алба, Австралийн Олон Улсын Тусламжийн Байгууллага, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Люксембург болон Бразил зэрэг орнуудын засгийн газар гэх мэт хандивлагчид хамтран хүмүүнлэгийн тусламж хүргэх ажлыг зохион байгуулахын зэрэгцээ улам бүр хүндэрч буй нөхцөл байдалд олон улсын анхаарлыг хандуулах зорилгоор олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандан, нөхцөл байдлыг мэдээлэхэд тэдэнтэй хамтран ажиллаж байна.

Сургамж #1: Хүмүүнлэгийн тусламжид нэгдэн, Засгийн Газрын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд дэмжлэг үзүүлэхийг хүссэн байгууллагуудад тулгарч буй нийтлэг нэгэн бэрхшээл бол байгалийн гамшиг хүнд хэрхэн нөлөөлж буйг үнэлэх нийтлэг арга хэрэглүүр байхгүй байгаа явдал юм. Засгийн Газрын зүгээс үнэлгээ хийсэн ч хүнд үзүүлж буй нөлөөнөөс илүүтэйгээр мал сүрэгт хэрхэн нөлөөлж байгааг үнэлэхэд чиглэсэн байна. Эрүүл мэнд, хоол тэжээл, ус хангамж эрүүл ахуй, нийгэм сэтгэл зүй, боловсролын мэргэжилтнүүдийг оролцуулан зөвшилцсөн, ОБЕГ-аас авч хэрэгжүүлэх үнэлгээний багцтай болох шаардлагатай байна.

Сургамж #2: Сумдын эмнэлэг, эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, дотуур байрны халаалтын систем болон урьдчилан сэргийлэх тарилга эм бэлдмэл хадгалах хөргүүр зэрэг чухал шаардлагатай зүйлсийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тодорхой төсвийг салбар яамдын зүгээс анхаарч, энэ тал дээр байнга хяналт тавих шаардлагатай байна. Санхүүгийн нэмэлт дэмжлэг эх үүсвэр бий болсон тохиолдолд эдгээр байгууллагуудыг нарны болон салхины сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангах шаардлагатай.

НҮБ-ын Хүүхдийн Сангийн тусламжийн эхний цуваа 2-р сараас эхлэн зудад нэрвэгдсэн хүн амд хүрсэн бөгөөд тусламжийн арав гаруй цувааг илгээгээд байна. Эхний ээлжинд дулаан гутал, хөнжил, эрүүл ахуй ариун цэврийн хэрэгсэл, сургалтын материал, тоглоом зэрэг эд материалын тусламж үзүүлсэн бол дараа

дараачийн удаад түлш, нүүрс, хоол хүнс, бичил тэжээлийн бодис, баяжуулсан гурил, эмнэлгийн багаж хэрэгсэл, эм тариа зэрэг зүйлсийг зудад хамгийн их нэрвэгдсэн аймгуудад хүргэж, сургуулийн дотуур байрнуудын халаалтын шугамыг засварласан юм.

Хүүхдэд тусч буй сөрөг үр дагавар: Хэвлэл мэдээллээр малаа зуданд алдсан малчдын цөхрөл, сэтгэл санааны хүнд хэцүү байдал, амьжиргааныхаа эх үүсвэрийг алдсан нь айл өрхүүдэд хэрхэн хүндээр тусч байгаа талаар онцлон мэдээлж байгаа ч, энэ нөхцөл байдал дунд буй хамгийн эмзэг хэсэг болсон хүүхдүүдийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл дутагдаж байна. Зудад нэрвэгдсэн аймгуудад тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл наад зах нь 35 хувиар өсчээ. Энэ оны эхний саруудад Ховд аймагт 36, Баян-Өлгий аймагт 45 хүүхэд эндсэн байна. Энэ бол байж болшгүй өндөр үнэ төлөөс бөгөөд зудад нэрвэгдсэн аймгуудыг эмнэлгийн багаж хэрэгсэл, эм тариагаар яаралтай хангах арга хэмжээ авахын зэрэгцээ урьдчилан сэргийлэх боломжтой шалтгаанаар хүүхдийн амь нас эрсдэж буй байдлыг цаашид гаргуулахгүй байхын төлөө дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авах шаардлагатай байна.

Сургамж#3: Сумдын эрүүл мэндийн төвүүдийн төсвийн тэгш бус, хүрэлцээгүй байдал зэргийг хянан үзэж, ялангуяа алслагдмал, зам харилцаа муутай газруудыг өвлийн хамгийн хүнд үеүдийг давантуулахад нэн шаардлагатай эм тариа, тоног төхөөрөмжөөр хангах явдал чухал байна. ЭМЯ-наас эдгээр эмнэлгүүд, эрүүл мэндийн төвүүдэд нэн шаардлагатай эм тариа, тоног төхөөрөмжийг бодитой, өвөл цагт хүрэлцээтэй хэмжээгээр нөөцлөн, өвлийн эхэнд бэлдэх шаардлагатай байна. Тав хүртэлх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдтэй айл өрхөд хүмүүнлэгийн тусламжийг эн тэргүүнд хүргэхэд анхаарах хэрэгтэй.

Хүүхдийн эндэгдлийн зонхилох шалтгаан нь амьсгалын замын хурц өвчлөлийн хүндрэл болон хатгалгаа гэсэн дүгнэлт гарсан ч, хоол тэжээлийн архаг дутагдал, рахит, цус багадалт зэрэг суурь өвчлөл үндсэн шалтгаан болж байгааг онцгой анхаарч, хүүхдийн дархлааны тогтолцоог сулруулдаг эдгээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна. НҮБ-ын Хүүхдийн Сан зудад нэрвэгдсэн 5 аймгийн 12,000 хүүхдэд зориулсан хоол хүнсний зүйлсийн багц, баяжуулсан гурил

зэргээр тусламжийг илгээж, Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудад гурван автомашиныг тусламж үйлчилгээг цаг алдаггүй хүргэхэд нь туслах зорилгоор олгоод байна.

Сургамж#4: Монгол Улсын хэмжээнд зөвхөн баяжуулсан гурил үйлдвэрлэн борлуулах шийдвэр гаргах нь чухал байна. Бичил тэжээлийн бодисуудыг нөөцлөн, өвлийн хахир хатуу цагт бэлдэх зорилгоор хуваарилан түгээж, үндэсний хэмжээнд Д аминдэм болон төмрийн бэлдмэлийг хангахад анхаарах хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан Засгийн Газраас улсын хэмжээнд үйлдвэрлэж буй бүх гурилыг бичил тэжээлийн бодисоор баяжуулах, мөн зөвхөн баяжуулсан гурилыг импортлох тухай шийдвэр гарган, хэрэгжилтийг хангахыг зөвлөж байна. Зөвхөн энэ арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хүмүүсийн амь насыг аварч, цаашид гарах эрүүл мэндийн зардлыг багасгах боломжтой.

Гамшгийн үр дагавар удаан хугацаанд үргэлжилнэ:

Зудад нэрвэгдсэн хүн амын тоо нэмэгдэж, тэдэнд тусч буй нөлөө улам хүндэрч байсантай зэрэгцээ манай улс дахь НҮБ, Засгийн Газар болон бусад түншүүдтэй хэлэлцэн зөвшилцөж хамтран ажиллах замаар авах шаардлагатай хариу арга хэмжээний уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах тал дээр ажиллаж байна. Эсэн мэнд амьдрахуй, Эрүүл мэнд, хоол тэжээлийн бүлэг дараах асуудалд онцгой анхаарал хандуулж байна: а) цаашид үргэлжлүүлэн авах шаардлагатай арга хэмжээ б) цаашид үүсэн бий болж болзошгүй асуудлууд – хүнсний хомсдол, хоол тэжээлийн асуудлууд, өвчлөл дэгдэлт г.м в) хойшид зуд болоход дахин ийм хүнд байдал үүсгэхгүй байх үүднээс шийдвэрлэх асуудлууд болон амьжиргааны эх үүсвэрээ алдсаны улмаас ажил эрэлхийлж хот руу шилжин нүүх магадлал бүхий хүн амд шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх. Эдгээр асуудлаар төлөвлөгөө боловсруулан, авах хариу арга хэмжээний зохицуулалтыг хангаж, 5-р сарын 12-нд Женев хотноо эхлэх НҮБ-ын Хүмүүнлэгийн Тусламжийн Зохицуулалтын Албанаас зохион байгуулсан олон улсын зөвлөгөөний үеэр танилцуулсан юм. Уг саналд 18 сая ам. долларын тусламжийн үйл ажиллагааг НҮБ-ын төрөлжсөн 7 байгууллага, төрийн бус зургаан байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх саналыг тусгасан. Санхүүжилтийг бүрдүүлэх ажил одоо өрнөж байна.



© UNICEF Mongolia/2010/Andrew Cullen

Сургамж #5: Зудаас гадна Монгол Улс үер ус, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт өртөх эрсдэлтэйг харгалзан салбар яамдын хувьд онцгой байдал, бэлэн байдлын төлөвлөгөө гаргасан, ажилтнууд нь сургагдсан байсан ч зудын нөхцөл байдлаас үзэхэд эдгээрийн хэрэгжилтэд анхаарах шаардлагатай байгаа нь ажиглагдлаа. ОБЕГ нь үр дүнтэй ажилладаг хэдий ч салбар яамдын үүргийг гүйцэтгэх боломжгүй. Онцгой байдлын удирдлага зохицуулалтыг ОБЕГ-аас хангаж ажиллахдаа бүх яамдын зүгээс дэмжлэг авч, тэдгээр яамдын үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах шаардлагатай гэсэн үг юм. Эдгээр байгууллагуудын хооронд мэдээлэл харилцаа чухал ач холбогдолтой. Үндэсний болон олон улсын байгууллагууд энэ чиглэлээр бэлтгэлээ хангаж, хариу арга хэмжээ авах чиглэлээр ОБЕГ-тай хамтран ажиллах боломжийг хангах зорилгоор Монгол улсад цогц бүлгийн арга барилыг нэвтрүүлэхийг зөвлөмж болгож байна. Энэ нь үнэлгээний багууд болон арга хэрэглүүрүүдийг урьдчилан зөвшилцөн тодорхойлж, хэн юуг хаана хийж байгаа талаарх бүх мэдээлэл ОБЕГ-аар дамжин хангагдаж, хариу арга хэмжээ хангалтгүй хэрэгжиж буй газруудыг нэн даруй тодорхойлон, шаардлагатай арга хэмжээг авч, хандивлагчид болон тусламжийн байгууллагууд шаардлагатай тусламжийг зохих газарт нь богино хугацаанд хүргэх зэрэгт дөхөм болох юм.

Амьжиргааны гол эх үүсвэр болсон малаа зудад олноор нь алдсан малчин өрхүүд нийгэм сэтгэл зүйн хувьд хүнд дарамтанд орж байгаатай холбогдуулан гэр бүлээсээ хол, дотуур байранд амьдарч буй хүүхдүүдэд онцгой халамж анхаарал шаардлагатай болж байна. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн Сангаас 2010 оны 3-р сард 5 аймгийн 21 сумын 462 сургууль, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, олон нийтийн төлөөлөл, эцэг эхчүүдэд зориулж зудад нэрвэгдсэн малчин айл өрхүүд, тэдний хүүхдүүдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг зохион байгуулсан.

Онцгой байдлын бэлэн байдлын чиглэлээр үндэсний чадавхийг бэхжүүлэх, хүн амыг мэдээллээр хангах асуудал онцгой ач холбогдолтой байгаатай холбогдуулан Онцгой Байдлын Ерөнхий Газар болон Хүүхдийн төлөө газрын 30 мэргэжилтэн хөгжлийн төлөөх мэдээлэл харилцааны хүрээнд байгалийн

Сургамж #6: Цоги бүлгийн арга барилыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор цаашид зудын хор хохирлоос урьдчилан сэргийлэхийн тулд бүх салбарт авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа арга хэмжээг тодорхойлох зорилгоор туршлага сургамждаа дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай. Энэ нь бэлчээрийн менежмент болон тэжээлийн ургамал тариалах асуудлаас эхлээд эрүүл мэндийн төсөв, шаардлагатай хангамжийг нөөцлөх зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарна.

гамшиг, онцгой байдлын үед бэлэн байдлаа хангахын тулд гэр бүл, айл өрхүүд юу мэдэх ёстой, ямар арга хэмжээ авах талаар мэдээлэл боловсруулах сургалтанд хамрагдаад байна.

ЗУДАНД НЭРВЭГДСЭН ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХДҮҮДЭД УРТ ХУГАЦААНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

Сэтгэлийн болоод нийгмийн дэмжлэг үзүүлэх баг Увс аймгийн Түргэн сумын нутагт уулсын дунд байрлах Оюунаагийн гэрийг цаг гаруй хайсны эцэст олж очив. Оюунаа бол гуравдугаар ангийн боловсролтой, нүүдэлчин, малчин бүсгүй бөгөөд охин, хүргэн нялх ачийнхаа хамт сумын төвөөс алс хол гэрт амьдардаг. Энэ жилийн хахир хатуу өвөл Оюунаа болон түүний ар гэрийнхнийг төвөөс тусгаарлаад зогсохгүй, ахуй амьдралд нь хүнд цохилт өгсөн байна.



Оюунаад сэтгэлийн болоод нийгмийн дэмжлэг үзүүлэх багаас зөвлөгөө авч байгаа нь

нь дангаараа зудаас үүдэлтэй ядуурлыг даван гарахад нь айл өрхүүдэд тусалж чадахгүй. Иймд зуданд нэрвэгдсэн эмэгтэйчүүд, тэдний ар гэрийнхний амьжиргааг урт хугацаанд сайжруулах зорилгоор сэтгэлийн болоод нийгмийн дэмжлэгийг амьжиргааг дэмжих үйл ажиллагаатай уялдуулав.

Зуданд нэрвэгдсэн иргэдэд зориулсан сэтгэлийн болоод нийгмийн дэмжлэг



Увс аймагт зохион байгуулсан эрүүл мэнд, нийгмийн ажилтнууд, орон нутгийн засаг захиргааныханд зориулсан сургалт

“Зуданд би 500 малынхаа 300-г нь алдаж, хүргэн охин хоёр маань 1000 малаас ердөө 200-хан малтай үлдсэн. Бид малаа хорогдуулахгүйн төлөө хичээсэн ч яаж ч чадсангүй. Одоо би ирээдүйдээ маш их санаа зовж байна. Бас ийм юм болсонд ичиж байна” гэж Оюунаа ярилаа.

Оюунаа шиг ийм эмэгтэйчүүдэд туслахын тулд НҮБ-ын ХАС, Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв Монголын хамгийн алслагдсан баруун 4 аймаг болох Увс, Ховд, Говь-Алтай, Хөвсгөлд зуданд нэрвэгдсэн айл өрх, нэн ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүдэд сэтгэлийн болоод нийгмийн дэмжлэг, зөвлөгөө, эрүүл мэндийн үзлэг хийх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Гэвч энэ хөтөлбөр

4 сарын 22-24-ний өдрүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид, нийгмийн ажилтнууд болон орон нутгийн засаг захиргааныханд зориулж Увс аймгийн Улаангом хотод сургалт зохион байгуулж, сэтгэлийн болоод нийгмийн дэмжлэг үзүүлэх, бэрхшээлийг даван туулах арга зам, сэтгэл гутрал, шаналал, нойргүйдэл, архинд донтолтыг оношлох талаар зааж, сургалаа. Сургалтын багийн ахлагч, сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэд захирал Др. Насанцэнгэл сургалтанд оролцогчдын идэвхи, зуданд нэрвэгдсэн хүн амд туслах гэсэн хүсэл эрмэлзлийг нь хараад сэтгэл нь ихэд хөдөлсөн байна.

“Дүрд тоглох хэлбэрээр зөвлөгөө өгөх арга барилыг зааж, дадлага хийсэн нь зөвлөгөө өгөх техник, ур чадварыг эзэмшүүлэх хамгийн үрдүнтэй арга байлаа” гэж Др. Насанцэнгэл тэмдэглээд “сургалтын үед үнэхээр сэтгэл хөдлөм байв. Учир нь зарим оролцогчид өөрсдөө хамаг малаа алдчихсан юм шиг уйлж, зарим оролцогчид зуданд нэрвэгдсэн малчдын оронд өөрсдийгөө тавьж үзэж, ихэд идэвхитэй оролцлоо” гэж хэлэв.

Энэхүү сургалт нь тусламжийн зөвхөн эхлэл нь байсан бөгөөд сургалтын дараа эрүүл мэнд, нийгмийн ажилтнууд зуданд нэрвэгдсэн айл өрхүүдэд хүрч, тэдэнд шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлж, зөвлөгөө шаардлагатай айл өрхүүдэд дараа дараагийн зөвлөгөөнүүдийг өгөхөөр хувиар гарган ажиллав.

Тусламжийг хүлээж авлаа

Сэтгэлийн болоод нийгмийн дэмжлэг үзүүлэх баг Оюунаагийнхаар айлчилсан нь түүнд ихээхэн урам, ухаарал хайрлажээ. “Эмч, нийгмийн ажилтан манайхаар ирж, энэ хүнд нөхцөл байдлыг даван туулахад минь надад тусалж байгаад би их баяртай байна. Хэдийгээр ингэж малаа алдсаны хариуцлагыг би үүрэх ёстой ч гэсэн энэ нь миний буруу биш гэдгийг илүү сайн ойлголоо. Мөн ингэж олон малаа алдсан хүн нь ганцхан би биш гэдгийг ч бас ойлголоо. Гэлээ ч гэсэн энэ бодит байдалтай нүүр тулахад үнэхээр хүнд байна. Иймд цаашид иймэрхүү дэмжлэгүүдийг бидэнд өгч байвал сайн байна” гэж яриу.

Др. Насанцэнгэл Оюунаад дахин зөвлөгөө өгөхөөр болсон бөгөөд тэрээр “Малаа эргүүлж олж авахад нь бид түүнд тусалж чадахгүй ч гэсэн энэ бэрхшээлийг даван туулж, сэтгэлийн тэнхээтэй болоход нь түүнд тусалж, үүний үр дүнд Оюунаа цаашид хичээл зүтгэл гарган, ирээдүйнхээ төлөө ажиллана” гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийллээ.



Увс аймагт дэмжлэг үзүүлэх баг эрүүл мэндийн үзлэг хийж байгаа нь

Амьжиргааг сэргээх тухай

Хүмүүсийн уй гашуу, малын хорогдлыг шийдвэрлэсэн үйл ажиллагаанууд нь зуданд нэрвэгдсэн эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийнхэнд амьжиргаагаа сэргээх итгэл, боломж хайрлаж байна. НҮБ-ын ХАС, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам зуданд нэрвэгдсэн айл өрхийн амьжиргааг сайжруулах зорилготой нэг жилийн хугацаатай хөтөлбөр хэрэгжүүлж байгаа юм. Уг хөтөлбөрийн хүрээнд малчдын хүүхдүүдийн сургалтын төлбөрийг төлж, техник мэргэжлийн сургалтанд малчдыг хамруулж, жижиг бизнес эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, ногоо тарих сургалтанд тэднийг хамруулах юм.

Үүнийг сонсоод Оюунаа “өөрөө төдийгүй өрх бүлээрээ зуд шиг хүнд бэрхшээлүүдийг хэрхэн ажрахгүй давж гардаг болох талаар суралцаж, ур чадвараа сайжруулахыг би тэсч ядан хүсч байна” гэж хэллээ.

НҮБ-ын ХАС-ийн тусламж

2010 оны 1 дүгээр сард зуд ихэнх нутгийг хамрах үед Монгол Улсын Засгийн газар олон улсаас тусламж дэмжлэг хүссэн юм. Тэр цагаас хойш НҮБ-ын ХАС 600,000 гаруй ам.долларыг алслагдсан хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, зуданд нэрвэгдсэн эмэгтэйчүүдэд зориулан нөхөн үржихүйн эрүүл мэндийн багц, эм түгээх, сумын эмнэлгүүдэд эх баригч нарт зориулсан багц, аймгуудад эмнэл зүйн үйлчилгээний багц, жирэмсэн болоод хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдэд нэмэлт тэжээлийн бэлдмэл, дулаан хувцас, гутал өгсөн юм. Зуданд нэрвэгдсэн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн амьжиргаа, эрүүл мэнд, түүний дотор НҮЭМ-ийг сайжруулах төслийг Австралийн Засгийн газар санхүүжүүлж, Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамаар дамжуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ бүх үйл ажиллагаануудыг НҮБ-ын Хүүхдийн сангаар ахлуулсан эрүүл мэнд, амьжиргаа, хоол тэжээлийн асуудал хариуцсан хэсэг зохицуулан ажиллаж байгаа юм.



ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

ДЭМБ-ЫН МОНГОЛ УЛАСТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ СТРАТЕГИ 2010- 2015

Монгол улс сүүлийн арваад жилд хүн амын эрүүл мэндийг сайжруулах тал дээр тогтвортой амжилт гаргаж байна. Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах Мянганы Хөгжлийн Зорилтууд биелэх шатандаа явж байгаа бөгөөд халдварт өвчин ялангуяа дархлаажуулалтаар урьдчилан сэргийлж болох халдварт өвчний тархалт буурах хандлагатай байна.

Монгол улсын засгийн газар мянганы хөгжлийн зорилт 5-г хэрэгжүүлсний амжилт нь төрөхийн өмнөх асаргаа (87.7%), төрөх үед мэргэжлийн хүн байх (99.8%) гэсэн ойлголтуудтай холбоотой

Гэвч Монгол улс дэлхийн бусад орнуудын адил саяхан тохиолдсон дэлхийн санхүүгийн хямрал, хүнсний аюулгүй байдал, өсөн нэмэгдэж байгаа шатахууны үнэ, байгалийн гамшиг зэргээс хамаарсан улс төр, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудтай учраад байна. Дээрх хүчин зүйлүүд эрүүл мэндийн салбарт нөлөөлж байна. Засгийн газар нь эрүүл мэндийн үндэсний цогц бодлого, стратеги, төлөвлөгөөгөөр ард иргэдийн эрүүл мэндийг сайжруулахаар ажиллаж байгаа хэдий ч хэд хэдэн чухал асуудлуудыг нэмж тодруулах хэрэгтэй байна. Иймд, Монгол улстай Хамтран Ажиллах Стратеги (ХАС)

боловсруулах нь маш цагаа олсон зүйл бөгөөд энэ нь стратегийн чухал баримт бичиг болохын хувьд Монгол улсын эрүүл мэнд болон бусад холбогдох салбаруудад байгаа боломжууд мөн хүндрэлтэй асуудлуудыг тодруулах болно.

ДЭМБ-ын Хамтран Ажиллах Стратеги гэж юү вэ?

ДЭМБ-ын Хамтран Ажиллах Стратеги гэдэг нь тус улстай хамтран ажиллах хэтийн зорилтуудыг тусгасан ажлын дунд хугацааны төлөвлөгөө. Энэ нь хамтран ажиллах стратегийн ажлын хүрээг тодорхойлож өгсөн бөгөөд дунджаар 4-6 жилийн хугацаатайгаар төлөвлөсөн байдаг.

ДЭМБ-ын ХАС нь 2010-2015 онуудад Монгол Улсын ард иргэд, Монгол Улсын Засгийн газар болон бусад түншүүдтэй ДЭМБ-ын хамтран ажиллах стратегийн ажлын хүрээг тодорхойлж өгсөн.

ХАС-ыг боловсруулахад Засгийн газар тэр дундаа Эрүүл Мэндийн Яам, бусад хөгжлийн түншүүд болох төрийн байгууллагууд, хоёр талт болон олон талт агентлагууд, Нэгдсэн Үндэсний Байгууллагын (НҮБ) агентлагууд, төрийн бус байгууллагуудтай уулзалт, биечилсэн ярилцлага, сургалт, ХАС-ын үйл явцын үе шат бүрийг хэлэлцэх байдлаар зөвлөлдөн хэлэлцсэн.



Тус орны төлөө гэсэн хамтын сэтгэлгээ болон хариуцлага нь ХАС-ыг амжилттай хэрэгжүүлэх үндэс болно

Ирэх зургаан жилийн стратеги төлөвлөгөөнд (2010-2015) Монгол Улсын засгийн газрын эрүүл мэндийн салбар дахь Мастер төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх зорилтуудыг анхааран үзэж боловсруулсан. Үүнд:

- Улсын түвшинд хамтран ажилладаг түншүүд, үндэсний оролцогч талууд, засгийн газартай бүрэн зөвлөлдөж ДЭМБ-аар судлагдсан Монгол улсад тулгараад байгаа эрүүл мэндийн болон хөгжлийн тулгамдсан гол асуудлууд;
- Бусад хөгжлийн түнш байгууллагуудаас эрүүл мэндийн хөгжилд оруулж байгаа хувь нэмэр, 2008/2009 оны дэлхийн санхүүгийн хямралын үр дүнд гарч болох сөрөг нөлөөг танин мэдэж эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаанд гарсан завсардал ба хүндрэлтэй байдлуудыг тодруулсан;
- Өнгөрсөн ба өмнөх ХАС-ын хугацаан дахь ДЭМБ-ын хамтын ажиллагааг дүгнэсэн дүгнэлт;



- ДЭМБ-ын харьцангуй давуу тал;
- ДЭМБ-ын ажлын ерөнхий хөтөлбөр, дунд хугацааны стратеги төлөвлөгөөний стратеги зорилтууд, бүс нутаг болон дэлхийн хандлага, тэргүүлэх зорилтууд;

ХАС нь НҮБ-ын Хөгжлийн Тусламжын Хүрээнд (2012-2016) тусгагдах эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг тодорхойлоход хувь нэмрээ оруулах болно. НҮБ-ын Хөгжлийн Тусламжын Хүрээ нь Монгол улсын хөгжлийн үндэсний эрхэм зорилтуудыг дэмжих НҮБ-ын хамтарсан хариу арга юм.

Ирэх зургаан жилийн ХАС-т ДЭМБ-ийн таван үндсэн стратеги зорилтыг тусгасан:

- Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх замаар эрүүл мэндийн салбарыг бэхжүүлэх;
- Халдварт бус өвчин, гэмтэл, хүчирхийлэл болон эдгээрийг бий болгож байгаа хүчин зүйлсийг хянан тогтоох, урьдчилан сэргийлэлтийг сайжруулах
- Эрүүл мэндтэй холбоотой мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтыг тогтворжуулах, хурдасгах;
- Дархлаажуулалтаар сэргийлж болох өвчин, халдварт өвчнийг хянахтай холбоотой эрүүл мэндийн аюулгүй байдлыг бэхжүүлэх;
- Орчны эрүүл мэндийн удирдан зохион байгуулалтыг бэхжүүлэх

ХАС-ийн хэрэгжилт нь Монголын хүн амын эрүүл мэндийн хөгжилд чухал хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэлтэй байна.



**НИЙСЛЭЛИЙН ГЭР ХОРООЛЛЫН ОРШИН СУУГЧИД АМЬДРАХ ОРЧИН НӨХЦЛӨӨ
САЙЖРУУЛАХ ҮЙЛСЭД ХОШУУЧЛАН ОРОЛЦОЖ БАЙНА**

Улаанбаатар хотын гэр хорооллын хөгжлийн асуудал Монгол улсын хөгжлийн зорилтын нэгэн томоохон хэсэг болоод байна. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгаас нийслэл хот руу шилжих хөдөлгөөн эрс нэмэгдэж хүн амын тоо 10 жилийн өмнөхтэй харьцуулахад даруй 2 дахин нэмэгдэж 1 сая давсан байна. Үүний улмаас хотын дэд бүтэц, үйлчилгээний хүчин чадал хүрээгээ тэлэх шаардлагатай болсон хэдий ч хотын оршин суугчдын талаас илүү хувь нь гэр хорооллын бүсэд оршин сууж нийгмийн үндсэн үйлчилгээ хангалттай хүртэж чадахгүй байсаар байна.

Гэр хорооллын оршин суугчдад тулгараад буй нийтлэг бэрхшээлүүдийг хөнгөвчлөх зорилгоор НҮБ-ын Хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөрөөс “Улаанбаатар хотын гэр хорооллын нөхцлийг оршин суугчдын оролцоотой сайжруулах төсөл”-ийг 2009 оны сүүл үеэс сонгон авсан талбарууд дээр хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Тус төслийг Япон улсын засгийн газраас 5,8 сая ам доллараар санхүүжүүлж байна. Төслийн хэрэгжилтийн хүрээнд нийслэлийн 4 дүүргийн 5 гэр хорооллын бүсэд оршин суух 12,903 өрхийн 50,804 хүн ам ашиг тусыг нь хүртэх боломжтой болох ба хотын захиргаа, НҮБ-ХАБИТАТ, ЗТБХБЯ зэрэг талуудын хамтын ажиллагааны үндсэн дээр тус төсөл хэрэгжиж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ивээл доор төслийн үйл ажиллагааг олонд сурталчлан таниулах томоохон хэмжээний уулзалтыг 2010 оны 4-р сард хотын захиргааны байранд зохион байгуулав. Тус уулзалтын зорилго нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан төсөл хэрэгжиж эхэлснээс хойших болон цаашдын үйл ажиллагааг хотын оршин суугчдад өргөн хүрээнд таниулахад оршиж байв. Уулзалтад хотын дарга ноён Г. Мөнхбаяр, хотын орлогч дарга ноён Б. Мөнхбаатар болон НҮБ-ын Суурин зохицуулагч хатагтай Рана Флауэрс, Япон улсын Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга ноён

Такахиро Ишизаки гарын гадны төлөөлөгчдөөс гадна ЗТБХБЯ, НҮБХХ, ЖАЙКА, хотын захиргааны холбогдох албадуудын төлөөлөгчид байлцав. Тус уулзалт дээр ноён хотын дарга төслийн хүрээнд гэр хорооллын оршин суугчдын амьдрах орчин нөхцөл сайжран, ажлын байр нэмэгдэх боломж үүсч байгаад тус төслийн ач холбогдол оршиж байна хэмээн цохон тэмдэглэв.

Төслийн зорилго нь сонгон авсан гэр хорооллын оршин суугчдын амьдрах орчин нөхцлийг сайжруулахад чиглэгдэх бөгөөд төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн бүхий л шатанд төсөл хэрэгжих үндэс суурь нь ард иргэдийн идэвхитэй зохион байгуулалт, эв нэгдэл байх юм. Уулзалтын үеэр НҮБ-ХАБИТАТ-ын Техникийн асуудал хариуцсан ерөнхий зөвлөх ноён Бижэй Кармачарья манай орны хотуудын өнөөгийн онцлог нөхцөл байдалд тохируулан боловсруулсан оршин суугчдыг зохион байгуулах дөрвөн үе шат, 15 алхамт ажиллагаагаар хэрэгжих аргачлалаар төслийн үндсэн ойлголтыг тайлбарлав.

Үүний үр дүнд төслийн талбар тус бүрт хэд хэдэн “Оршин суугчдын зөвлөл-ОСЗ” –үүд үүсэн байгуулагдаад байгаа бөгөөд тэд орон нутгийн түвшинд тулгараад буй нийтлэг асуудал, бэрхшээлүүдийг авч үзэх зорилготой юм. Оршин суугчдын төлөвлөлтийн үйл явцын хүрээнд ОСЗ-үүд төслийн талбаруудад оршин суух иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан нийгмийн үйлчилгээ үзүүлэх 15 объектыг барихаар тодорхойлсон байна. Төсөлд хамрагдах оршин суугчдад ашиг тусаа өгөх халуун ус, хүүхдийн цэцэрлэг, сургуулийн өргөтгөл зэрэг объектуудыг энэ барилгын улиралд барьж эхлэх юм. Үүний зэрэгцээгээр төслийн хүрээнд явган зам, гүүр, гудамжны гэрэлтүүлэг, автобусны зогсоол, нийтийн бие засах газар зэрэг 48 жижиг байгууламжийг олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн оршин суугчдын ажил гүйцэтгэх гэрээгээр төслийн талбаруудад барих юм.



НҮБ-ЫН ХХААБ-ЫН ГАМШГИЙН АЮУЛААС ХАМГААЛАХ БА СЭРГЭЭН БОСГОХ ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ НЭГЖ (ERCU)

Өнгөрсөн өвөл 8 сая гаруй мал хорогдов

“Зуд” гэдэг үг нь монголчуудын сэтгэлийг түгшээсэн, малчдын амьжиргаа болох олон сая малын хорогдлыг агуулсан ойлголт юм. Хүйтний эрч -50С хүртэл огцом буурахад, цочир хүйтэнд нэрвэгдсэн малын биеийн дулаан арилж, амийг нь тэтгэх дулааны хэмжээнээс хэт хөрөх үед гипотермия болж, улмаас мал осгож үхдэг билээ. Биеийн хэт хөрөлт буюу гипотермия болох аюулаас малаа хамгаалах эд хөрөнгө, бололцоо малчдад хомс байсан тул мал нь олон саяаар осгож, хорогдсон байна.

2009-2010 оны Зудын гамшиг тохиолдохын өмнө өнгөрсөн намар хийсэн тооллогоор 44 сая мал байсан бол 8 сая гаруй мал Монголын нийт нутгаар өнгөрсөн Зудын үеэр хорогдсон байна. Энэхүү эмгэнэлт үйл явдлын хариуд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (НҮБ-ын ХХААБ) нь 7 аймгийн 22 сумын 2614 малчин айл өрхүүдэд гамшигийн аюулаас хамгаалах шуурхай тусламжийг үзүүлсэн. 2010 оны Монголын Зудын Уриалгад НҮБ-ын ХХААБ нь ХАА-н салбартай холбогдох уриалгыг тэргүүлж гаргасан бөгөөд үндэс малын хашаа, саравчийн материал, тэжээл болон малын эм бэлдмэл нийлүүлэх зэрэг тусламжийг үзүүлж, малчдыг дэмжихийг уриалсан байна. Үүнд 4.2 сая ам. доллар хэрэгтэй гэж үзжээ.

НҮБ-ын ХХААБ нь нэн даруй үзүүлэх тусламжийн хүрээнд эмзэг бүлгийн малчин айл өрхүүдийн үндсэн чухал эд хөрөнгө болох малыг нь аврах, амьд гарсан малыг тэнхрүүлэх талаар арга хэмжээ авахыг уриалан, үүнд анхаарал хандуулж байна. НҮБ-ын ХХААБ-аас үзүүлсэн тусламжийг хүргэх цуваа 2300 тонн хорголжин тэжээлийг сумын төвүүдэд хүргэж, нийлүүлсэн бөгөөд тэндээс сонгогдсон малчин айл өрхүүдэд хуваарилсан болно. Түүнчлэн, төлийг аврахад зориулж 13 гаруй тонн хуурай сүү, малын эм бэлдмэл болон нэг удаагийн

тариур, зүү, өлсөж сульдсан, малын өвчин, шимэгч паразит хорхойнд баригдаж доройтсон малд шаардлагатай амин дэм, тэнхрүүлэх эм бэлдмэлийг үр шим хүртэгч малчин айл өрхүүдэд энэхүү тусламжийн хүрээнд нийлүүлсэн.

НҮБ-ын ХХААБ-ын Гамшигийн аюулаас хамгаалах ба сэргээн босгох тусламжийг зохицуулах нэгж (ERCU) нь НҮБ-ын ХХААБ-ын Улаанбаатар дахь Шадар суурин төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар, НҮБ, ТББ-ууд болон бусад холбодох талуудтай хамтран ажиллаж, өвлийн хүнд нөхцөлд хичээнгүйлэн зүтгэж, гамшигт нэрвэгдсэн айл өрхүүдэд тусламжийг нийлүүлж, хүргэсэн болно. Зудын гамшигт нэрвэгдсэн долоо аймагт хүмүүнлэгийн тусламжийг цаг хугацаанд нь хүргэхийн тулд НҮБ-ын ХХААБ нь Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар болон “Хөдөөгийн хөрөнгө оруулалтыг дэмжих төв” ТББ-тай логистикийн асуудлуудыг шийдвэрлэх талаар хамтран ажилласан. ХХОДТ ТББ нь НҮБ-ын ХХААБ, орон нутгийн удирлага болон малчдын бүлгүүдтэй үр бүтээлтэй хамтран ажилласны үр дүнд зохих шалгуурыг бүрэн хангасан үр шим хүртэгч малчин айл өрхүүдийг сонгосон бөгөөд тэдгээр үр шим хүртэгчид нь малынхаа талаас дээш хувийг алдаж аюулд нэрвэгдсэн боловч амьжиргааг нь сэргээн босгож болохуйц тооны малтай үлдсэн айл өрхүүд хамрагдсан байлаа.

Урьдчилсан тайлангуудаас үзвэл хандивлагчдаас олгосон тусламжийн хандив нь цагаа олсон, үнэлж баршгүй хувь нэмэр болжээ. Гэсэн хэдий ч НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь үйл ажиллагаа нь үүгээр зогсохгүй юм. Яагаад гэвэл Монгол орны эрс ширүүн уур амьсгал, хахир өвөл нь цаашид ч мал аж ахуйн салбарт хүнд хохирол учруулах аюултай бөгөөд үүний улмаас малчдын амьжиргаа болон хүнсний баталгаат байдалд аюул дахин учирч болзошгүй юм.

Зудын гамшигт нэрвэгдсэн хүн амын аюулгүй байдал болон амьжиргаанд тохиолдож болзошгүй аюулын эрсдлийг бууруулах бэлтгэлийг хангахын тулд, НҮБ-ын ХХААБ нь “Зудын гамшиг болон өвлийг даван туулах нь” гарын авлагыг боловсруулж, малыг гипотермиягаас хамгаалах хашаа, саравчийг сайжруулах, салхи, шуурганаас хамгаалах арга технологийг боловсруулж, дэмжлэг үзүүлсээр байна. Түүнчлэн, мал дотоод халуунаа хэт алдахгүйн тулд ямар тэжээлээр тэжээх талаар ойлголтыг төлөвшүүлнэ. Өвөлжилтийн талаарх зохих мэдлэг бүхий мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтыг зохион байгуулах болон орон нутгийн

тодорхой нөхцөлд МАА-н зохистой аргуудыг хэрхэн нэвтрүүлэх талаар бодит зөвлөгөө өгөх юм. Мал болон малын гаралтай бүтээгдэхүүнийг зохих цагт нь бэлэн мөнгө болгож хувиргах нь зуд хэмээх байгалийн гамшигийг даван туулах чадавхийг бэхжүүлэх болон өвлийн бэлтгэл, тэжээлийн нөөцийг хангахад чухал юм.

Дээрх чиглэлд хийх ажил их байна. Үүнд гамшигийн аюулаас урьдчилан сэргийлж, бэлтгэлийг хангах болон амьжиргааг нөхөн сэргээхэд арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийн тулд хандив, хөрөнгө шаардлагатай байгаа юм.



ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ НЬ ҮНДЭСНИЙ ЗОРИЛТ ЮМ

Олон улсын хөдөлмөрийн байгууллага 2002 оноос эхлэн жил бүрийн 6 сарын 12-ны өдрийг Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхий нийтийн өдөр болгон тэмдэглэж, хүүхдийн хөдөлмөрийн талаарх хүмүүсийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, дэлхийн нийтийн анхаарлыг татах зорилгоор зохион байгуулж эхэлжээ. Энэ жилийн хувьд Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхий нийтийн өдрийг “Зорилгодоо хүрье – Хүүхдийн хөдөлмөрийг устгая” уриан дор зохион байгуулж байна.

2010 оны 5 сарын 4-ний өдөр ОУХБ-ын БНХАУ, Монгол улсыг хариуцсан товчооны захирал хатагтай Ан Хэрберт Гадаад харилцааны дэд сайд Б.Болорт итгэмжлэх жуух бичгээ өргөн барилаа.

Хатагтай Хэрберт ОУХБ-т 19 жил ажиллаж байна.

Энэ оны 5 сарын байдлаар өнгөрсөн өвлийн зуданд нэрвэгдсэн 159350 хүүхэдтэй 126750 айл байгаа бөгөөд Төв, орон нутгийн засаг

захиргаа, олон улсын байгууллагуудын үзэж байгаагаар зуданд нэрвэгдсэн олон өрх айл албан бус эдийн засаг, ялангуяа албан бус уурхайд шилжин ажиллах төлөвтэй байна. Энэ тохиолдолд, эдгээр өрх айлын олон мянган хүүхэд сургууль завсардаж, хүүхдийн хөдөлмөр эрхлэх эрсдэл бий болж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн асуудал нь дэлхий нийтийн анхаарлыг татаж буй асуудлуудын нэг бөгөөд энэ оны 5 сарын 10-11-нд Хүүхдийн хөдөлмөрийн дэлхийн чуулга уулзалтыг Нидерланд улсын Гаага хотноо зохион байгууллаа. 80 орны 450 гаруй төлөөлөгч оролцсон энэ уулзалтаар хүүхдийн хөдөлмөрийг устгах чиглэлээр авч хэрэгжүүлж буй дэлхий нийтийн оролдлого, санаачлагыг “эрс нэмэгдүүлэх”, хүүхдийн хөдөлмөрийн асуудалд нэн түрүүнд анхаарлаа хандуулах, хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллыг сайжруулах, боловсролыг дэмжих хөтөлбөрүүдийн нэг хэсэг болгох зэрэг улс төрийн үүрэг амлалт авах замаар 2016 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахаар санал нэгдсэн байна.

Монгол улсын Засгийн газар, Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний амьжиргааг хөдөлмөр эрхлэх үр чадварыг нь сайжруулах” төслийн баримт бичигт гарын үсэг зурлаа.

Уг төсөл Чех улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр нэг жилийн хугацаанд хэрэгжинэ.

Монгол улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг тэмцэх санхүүгийн хэрэгцээний талаар хуралдсан тусгай хуралдаанд оролцож, хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Монголын Засгийн газраас авах арга хэмжээ, үүрэг амлалтын талаар үг хэлжээ.


Монгол улсын хувьд, гурав дахь үе шатандаа хэрэгжиж буй ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах төсөл нь Монгол улсад 1999 оноос хойш хэрэгжиж байгаа бөгөөд хүүхдийн хөдөлмөрийг устгах, олон нийтийн анхаарал мэдлэгийг сайжруулах чиглэлээр нилээд үр дүнтэй ажиллаж байна. Төслийн хүрээнд төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагуудын санаачлагаар байгуулсан Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг үндэсний сүлжээ, “Хүүхэд ба Сэтгүүлч” сэтгүүлчийн клуб, олон

нийтэд суурилсан хүүхдийн хөдөлмөрийн мониторингийн тогтолцоо, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ, сургуулиас завсардсан хүүхдүүдэд албан бус боловсрол олгох зэрэг ажлуудыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлж байна.

Төслийн үр дүнд 8056 охид хөвгүүдэд боловсролын болон боловсролын бус бусад үйлчилгээг хүргэснээр тэднийг хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлж, хөндийрүүлж чадсан байна. Эдгээр хүүхдүүдийн 3842 нь хүүхдийн хөдөлмөр эрхэлж байсан, 4214 нь хүүхдийн хөдөлмөр эрхэлж болзошгүй эрсдэл бүхий хүүхдүүд байжээ. Түүнчлэн, дээрх хүүхдүүдийн 4425 нь албан бус сургалтад хамрагдаж, 4342 хүүхэд ерөнхий боловсролын сургууль болон албан бус сургалтын холимог хэлбэр, 701 хүүхэд мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдсан байна. Өнгөрсөн оны зудны улмаас хүүхдийн хөдөлмөрийн асуудал дахин нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд үүнд ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах төслийг үүрэг оролцоо ихээхэн байгааг тэмдэглэж хэлэх нь зүйтэй.

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар илүү мэдээлэл авахыг хүсвэл www.ipecmon.mn, www.stop-childlabour.mn болон www.networkchildlabor.mn вэбсайтууд руу хандана уу.

ШИНЭ НОМ - NEW PUBLICATIONS



Down to Earth
Simplified guide to the Convention to Combat Desertification

НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенцийн халбарилсан гарын авлага



UNDP ON EARLY RECOVERY
2009 – 2010 MONGOLIA DZUD

Эрт үеийн сэргэн босголын хөтөлбөр
Зүд 2009-2010



UNCCD POLICY BRIEF - 2
LAND a tool for climate change mitigation

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцоос баримтлаж байгаа бодлогын товчоон - 2 ГАЗАР бол уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах нэг хэрэгсэл мөн



НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН
ГАМШИГЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ
ӨӨРИЙГӨӨ ХҮРЦААХҮЙ-2



Human Development Report 2009
Overcoming barriers:
Human mobility and development

Human Development Report 2009
Overcoming barriers:
Human mobility and development




State of the World's Children 2009
Maternal and Newborn health

Дэлхийн хүүхдийн байдал 2009
Эх, Нялхын эрүүл мэнд




The State of the World's Children
Special Edition
Celebrating 20 Years of the Convention on the Rights of the Child

Дэлхийн хүүхдийн байдал тусгай дугаар
Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 20 жилийн ойд



International Conference on Population and Development
15 year after the International Conference on Population and Development

Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурлаас хойших 15 жилд




Trade Policy and Human Development in Mongolia

Монгол улсын худалдааны бодлого ба хүний хөгжил




UNDP Pamphlet



Comprehensive Review of the National Response to HIV and STIs in Mongolia
October 2008

ХДХВ, ДОХ, БЗДХ-ын эсрэг үндэсний хариу арга хэмжээний хөндлөнгийн цогц үнэлгээ
Аравдугаар сар 2008




Children and Women in Mongolia

- Current situation
- Future goals
- Монгол улсын хүүхэд, эмэгтэйчүүд
- Өнөөгийн байдал
- Ирээдүйн зорилтууд




New Horizons
December - 2009

Шинэ мэдэц
2009 оны 12 сар



Mini UN
National Forum for Mongolian Youth and Children

Мини НҮБ
Монголын хүүхэд, залуучуудын үндэсний чуулган



Guide for Designing Results-oriented Projects and Writing Successful Proposals

Үр дүнд чиглэсэн төсөл боловсруулж, санал бичих гарын авлага

and more / болон бусад